

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны
2024 оны 03 сарын 22 өдрийн
87 албан бичгийн хавсралт

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2024 ОНЫ
3 ДУГААР САРЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Хийгдэх ажил	Хүрэх үр дүн	Хугацаа	Биелэлт
1	Хугацаатай мэдээ, тайлан гаргах	Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг	дараа сарын 02-ны дотор	2024 онд манай байгууллагад 55,361.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 39,979.4 мянган төгрөгийг зарцуулж 15,381.5 мянган төгрөг тайлант хугацаанд зарцуулагдаагүй байна.
		Шилэн дансны мэдээллийг нэгдсэн цахим санд оруулах	Дараа сарын 08-ны дотор	Тайлант хугацаанд оруулбал зохих 14 мэдээллийг хуулийн хугацаанд нь оруулсан.
		Нийгмийн даатгалын тайлан гаргаж, хүргүүлэх	Дараа сарын 05-ны дотор	2-р сарын НДШ-ийн тайланг хуулийн хугацаанд илгээж, тайлагнасан.
2	Сум дундын ойн ангийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга бат сайжирна.	3 сар	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Сум дундын ойн ангийн 2020-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж шалгалтаар улсын ахлах байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлсэн. Албан шаардлагын биелэлт тооцох хугацаа болоогүй.
3	Сум дундын ойн ангийн 2023-2024.03 сар хүртэлх үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	3 сар	Байгууллагын 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Сум дундын ойн ангийн 2023-2024.03 сар хүртэлх үйл ажиллагаанд дотоод аудит хийгдэж байна. Шалгалтын явц 20 хувьтай үргэлжилж байна.
4	Аймгийн хөрөнгө оруулалтын ажлын үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга бат сайжирна.	3 сар	Байгууллагын 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу 2022-2024.02 сар хүртэлх хугацааны санхүүгийн баримтад хяналт шалгалт хийгдэж байна. Шалгалтын явц 10 хувьтай үргэлжилж байна.
5	Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-т гүйцэтгэлийн хяналт хийх	-	3 сар	Аймгийн засаг даргын 02 дугаартай удирдамжийн дагуу Тохижилт ОНӨААТҮГ-т гүйцэтгэлийн аудит хийхээр материалаг татан аваад байна. Шалгалтын явц 10 хувьтай байна.
6	Шилэн дансны тухай хуулийн	Шилэн дансны тухай хуулийн	3 сар	Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн төсөвт, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нийт 50

	хэрэгжилт хангуулах	хуулийн хэрэгжилт хангагдах		байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг. 2 дугаар сарын шилэн дансны мэдээ оруулалтын байдалд хяналт шалгалт хийсэн бөгөөд хуулийн хэрэгжилт 97.7 хувьтай байна. Энэ нь өмнөх сараас 1.1 хувиар буурсан хэдий ч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
7	Мэдээллийн ил тод байдлыг хангах	Мэдээллийн ил тод байдал хангагдах	03 сар	Мэдээллийн ил тод байдлыг хангаж, ойлгомжтой байлгах үүднээс байгууллагын веб хуудас болон самбарт 9 мэдээ мэдээллийг байршуулсан. Байгууллагын facebook хуудас https://www.facebook.com/profile.php?id=100090091147081/ -аар 39 мэдээллийг иргэд олон нийтэд түгээж ажиллалаа.
8	Бусад ажил	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна.	03 сар	1. Аймгийн удирдах ажилчдын шуурхай зөвлөгөөний 2 удаагийн хурлаас өгсөн 4 үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь ХШҮ-ний хэлтэст хүргүүлсэн.
				2. 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдөр Төрийн аудитын газраас зохион байгуулсан "Төсвийн захирагч, төсөв санхүү хариуцсан албан хаагч нарт зориулсан уулзалт, хэлэлцүүлэг"-т 4 албан хаагч хамрагдсан.
				3. 2024 оны 3 дугаар сарын 6-ны өдөр "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангуулах тухай" сэдвээр шинээр санхүүгийн албанд томилогдсон болон сонирхсон төрийн албан хаагчдад зориулан сургалт зохион байгуулан ажилласан. Сургалтад Говьсүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар- 1 албан хаагч, Сум дундын Ойн анги-1 албан хаагч, Говьсүмбэр аймгийн ЗДТГ-5, 4-р цэцэрлэг-1 албан хаагч, Ус-Ду ОНӨААТҮГ- 2 албан хаагч, Сүмбэр сумын ЗДТГ-2 албан хаагч, Баянтал сумын ЗДТГ-1 албан хаагч, Шивээговь сумын ЗДТГ-2 албан хаагч, Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж-1 албан хаагч, Нийгмийн даатгалын хэлтэс -2 албан хаагч, Говьсүмбэр аймгийн Худалдан авах ажиллагааны газар-1 албан хаагч, Цөм сүргийн үржлийн төв-1 албан хаагч, Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар -1 албан хаагч нийт 21 албан хаагч хамрагдсан.
				4. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдөр "Байгууллага, аж ахуй нэгжийн дэргэдэх эцэг, эхийн зөвлөл"-ийн гишүүдийг чадавхжуулах болон "Гэр бүлийн боловсрол олгох" 8 модуль сургалтад амжилттай хамрагдаж, гэрчилгээ авсан.
				5. 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Цахим хөгжил харилцаа холбооны яамнаас

				"Digital First – D1" түр арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан сургалт болон ICT EXPO арга хэмжээнд 4 албан хаагч хамрагдсан. 6. 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдөр "Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын хэрэгжилтийн талаар, Санхүүгийн анхан шатны баримтад хэрхэн бүртгэгдэж байгаа талаар мэдээлэл солилцох өдөр" арга хэмжээг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд Сүмбэр сумын ЗДТГ, Шивээговь сумын ЗДТГ, Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Шивээговь сумын Соёлын төв хариуцсан санхүүгийн ажилтан нар оролцож мэдээлэл солилцсон. 7. Төрийн албаны салбар зөвлөлийн "7:4:10" сургалтын хөтөлбөрийн дагуу 2024 оны 03 дугаар сарын 14, 21-ний өдрийн вебинар сургалтад 4 албан хаагч хамрагдсан. 8. Аймгийн ИТХ-аас санаачилсан уриалгын дагуу Төрийн албан хаагчид малчин түмэндээ тусалж, сэтгэлийн дэм өгөх "Бид хамтдаа аян"-д нэгдэж, хуваарилсан малчин өрхдөө 100,000 төгрөгийн тусламж үзүүлсэн. 9. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр албаны даргаар батлуулсан. 10. 2024 онд хийх дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө, сургалтын төлөвлөгөө, БНШК-ЫН төлөвлөгөө, ёс зүйн зөвлөлийн төлөвлөгөө, Байгууллагын эцэг, эхийн зөвлөлийн төлөвлөгөөг тус тус боловсруулан батлуулсан.
--	--	--	--	--

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

Дотоод аудитор:



Л.Эрдэнэчимэг